



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/11

Алтанбулаг

Халдвар хамгааллын дэглэмийг сахиулж,
ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Түр журам батлах тухай" 156 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01 тоот албан даалгавар, Аймгийн Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот албан даалгавар, сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн А/01 тоот захирамж, сумын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод коронавируст халдвар /ковид-19/-ын тохиолдол эрс нэмэгдэж, орон нутгийн иргэдийг татан авах тохиолдолд халдвар тархах эрсдэлтэй нөхцөл үүссэнтэй холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийг дуустал хугацаанд авто замын хяналтын цэгээр сумын Онцгой комиссын зөвшөөрөлтэй зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, бусад зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласугай.

2. Гэрийн ажиглалтанд байх хугацаанд хяналт тавих түр журмыг энэхүү захирамжийн хавсралтаар баталсугай.


3. Авто замын хяналтын цэгийг 3 дугаар багийн Их овооны урд байрлах авто зогсоол руу шилжүүлж ажиллуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ү.Янжиндулам/-д даалгасугай.

4. Сумын ойн сан гэрээгээр эзэмшигч "Ойн хамт олон" ГҮТББ-аас хандиваар өгсөн 3 метр куб түлээний модыг замын хяналтын цэгийн хэрэглээнд зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нярав /Э.Зориг/-т зөвшөөрсүгэй.

5. Дээрх үйл ажиллагаанд гарах зардлыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны сумын Онцгой комиссын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан /Э.Цэнд-Аюуш/-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа /Д.Наран/, Засаг даргын Тамгын газрын дарга /Ү.Янжиндулам/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын
Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
А/11 тоот захирамжийн хавсралт

Улаанбаатар хот /Улаан бүс/-оос ирсэн иргэдийн
гэрийн ажиглалтанд байх хугацаанд хяналт тавих түр журам

Сумын онцгой комиссоос Улаанбаатараас ирсэн иргэдийг байгууллагуудад хуваарьлан өгнө.

Төрийн байгууллагууд байгууллагын даргын тушаалаар нэг ажилтанд нэг өрх зарчмаар хариуцуулан өгнө.

Хариуцаж авсан ажилтан өдөр бүр тэмдэглэл хөтлөнө.

Гэрийн ажиглалтад байгаа иргэнтэй өдөрт нэг удаа утсаар харилцаж, хяналт тавьж мэдээлэл зөвлөгөө өгнө.

Мөн өдөрт нэг удаа тухайн иргэний байрлаж байгаа хаягт очиж хашааны гаднаас утсаар холбогдон дуудаж гэр бүлийн гишүүдийг гаднаа гарч ирэхийг хүсч өрхийн гишүүдийг тоолно. Баримтжуулж тэмдэглэл хөтлөнө.

Эрүүл мэндийн төвөөс өдөрт нэг удаа эрүүл мэндийн асуумж авна.

2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөрөөс эхлэн 1 өдөр өнжөөд 14 цагаас өрхөд ус нэгдсэн журмаар хариуцаж байгаа байгууллагын захиалгаар түгээнэ.

Сумын шуурхай штабт өдөр бүр 16⁰⁰ цагт гэрийн ажиглалтанд байгаа иргэдийг хариуцан ажиллаж байгаа байгууллагын удирдлагууд ажиглалт хийсэн, мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч хамтран ажилласан болон бусад ажлын мэдээ өгнө.

Сумын шуурхай штаб мэдээг нэгтгэн аймгийн Онцгой комисст хүргүүлнэ.

Гэрийн ажиглалтын хугацаанд дэглэм бариагүй тохиолдолыг мэдсэн даруйдаа сумын шуурхай штабын даргад танилцуулж баримт нотолгоог өгнө.

Шуурхай штабын дарга Цагдаагийн хэсэгт хэрэг бүртгүүлж, гэрийн ажиглалтын хугацаа дууссаны дараа Зөрчлийн хуулийн хариуцлагыг тооцно.

Шуурхай штабаас гэрийн ажиглалтанд байгаа иргэдийн судалгааг бүх төрийн байгууллагын ажилтан албан хаагчдад нээлттэй ил тод мэдээлж хяналт тавих боломжоор хангана.

Авто замын пост болон шуурхай штабын байранд гэрийн ажиглалтанд байгаа иргэдийн судалгааг ил тод байршуулна.

оОо

